



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/263

Булган сум

Аймгийн Цагдаагийн газрын
Замын цагдаагийн тасгийн алба хаагчдад
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2025 оны А/377 дугаар захирамжаар батлагдсан “Булган аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам”-ын 5.1.2 дахь заалт тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тээврийн цагдаагийн албаны түүхт 90 жилийн ойг угтаж Аймгийн Цагдаагийн газраас зохион байгуулж буй алба хаагчдаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах арга хэмжээнд 5,000,000 (таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх дэмжлэгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010352